

2024 ОНЫ 5 САЛБАРТ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭДИЙН СОЛОНГОС ХЭЛНИЙ ТҮВШИН ТОГТООХ ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

БНСУ-д Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны хүрээнд ehalamj.mn сайтаар 2024 оны Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлд бүртгүүлж, баталгаажсан иргэд дараахь хуваарийн дагуу шалгалтад амжилттай хамрагдахыг мэдэгдэж байна.

[Энд ХАА, ГАЗАР ТАРИАЛАН, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭ1, ҮЙЛЧИЛГЭЭ2](#)

[Энд АЖ ҮЙЛДВЭР](#) тус тус дарж үзнэ үү.

Шалгалт зохион байгуулагдах хугацаа:

- 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрүүдэд (3953) ХАА, ГАЗАР ТАРИАЛАН, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭ1, ҮЙЛЧИЛГЭЭ2 салбарт бүртгүүлсэн иргэд шалгалтад хуваарийн дагуу хамрагдана. /Ур чадварын шалгалтыг хялбаршуулан авна/
- 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрүүдэд (5354) АЖ ҮЙЛДВЭР салбарт бүртгүүлсэн иргэд шалгалтад хуваарийн дагуу хамрагдана. /Ур чадварын шалгалтыг хэмжих байдлаар авна/

Шалгалт зохион байгуулагдах газар, хаяг, утасны дугаар: 77121285, 70136992

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2 дугаар давхарт СВТ танхимд (ХУД. 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд группын замын урд талд)

Шалгалт өгөх иргэд дараахь зүйлд анхаарлаа хандуулна уу.

- Шалгалтын хуваарийг бүртгэлийн дугаар болон овог нэрээр шалгана.
- Хуваарьт өдөр, цагт шалгалтад орохдоо цахим үнэмлэх эсхүл гадаад паспорт (ТҮЦ машинаар уншуулсан лавлагаа)-ыг эх хувиар нь заавал биедээ авч ирнэ. Та бичиг баримтгүй бол шалгалтад орох боломжгүй.
- Шалгалтад хамрагдах цагийг хатуу баримтлан (1-р ээлж 9:00), (2-р ээлж 10:30), (3-р ээлж 13:00), (4-р ээлж 14:30) тус тус заасан цагт суудлаа эзэлсэн байх ба шалгалтын цагаас хоцорсон тохиолдолд нөхөж өгөх боломжгүй.
- Шалгалтын байранд бусдад саад учруулахгүй байж, шалгалтын комиссын зааврыг дагаж мөрдөнө.
- Шалгалт УНШИХ, СОНСОХ төрлөөр завсарлахгүйгээр 50 минутын турш үргэлжлэх тул шалгалтаас түр гарахыг хориглоно.
- Бямба, Ням гарагуудад шалгалт зохион байгуулагдахгүй. Хугацааны хувьд тухайн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөлт орж болно.

Шалгалтын үргэлжлэх хугацаа, шалгалтын бүтэцтэй танилцана уу.

Шалгалт явагдах ээлж	Шалгалтын заавар өгөх хугацаа	Үргэлжлэх хугацаа	
		Унших шалгалт (25мин)	Бичих шалгалт (25мин)
1-р ээлж	09:20-09:30	10:00-10:25	10:25-10:50
2-р ээлж	10:50-11:00	11:30-11:55	11:55-12:20
3-р ээлж	13:20-13:30	14:00-14:25	14:25-14:50
4-р ээлж	14:50-15:00	15:30-15:55	15:55-16:20

Шалгалтын төрөл	Шалгалтын Даалгавар	Нийт оноо		Хугацаа
		ХАА, газар тариалан, Барилга, Үйлчилгээ1, Үйлчилгээ2 салбарууд	Аж үйлдвэрийн салбар	
УНШИХ	20	80 оноо	110 оноо	25 мин
СОНСОХ	20			25 мин
НИЙТ	40	80 ОНОО	110 оноо	50 МИН

Салбар	Эцсийн байдлаар авах хүний тоо	Босго оноо
Аж үйлдвэр	2,939	110
ХАА газар тариалан	590	80
Барилга	250	80
Үйлчилгээ 1	10	80
Үйлчилгээ 2	472	80

- Эцсийн шалгаруулалт буюу хэлний шалгалт, ур чадварын шалгалтын дүнг нэгтгээд өндөр онооны дарааллаар төлөвлөж буй тоонд тэнцүүлнэ. Ижил оноотой бол багтана. **/Харааны харалган буюу өнгө ялгах чадваргүй бол хасагдана./**
- Солонгос хэлний шалгалт өгч тэнцсэн иргэн **ур чадварын шалгалтад ороогүй тохиолдолд эцсийн шалгаруулалтаас хасагдана.**

АЛБАН ЁСНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ХУУДСУУД:

- ✓ ХХҮЕГ-ын цахим хуудас (www.hudulmur-halamj.gov.mn)
- ✓ БНСУ-ын АҮХНХЭГ-ын Төлөөлөгчийн газрын цахим хуудас (www.monkor.net)
- ✓ ХЭЗОТ-ны СХТТШ-ын цахим хуудас (www.epstopik.hrdkorea.or.kr) –**Оноо харах**

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР